



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/60

Мандалговь


Төсвийн сар, улирлын хуваарь
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а дахь заалт, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, аймгийн Засаг даргын тамгын газрын төсвийн хуваарийг хоёрдугаар, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төсвийн хуваарийг гуравдугаар, сумын Засаг даргын тамгын газрын төсвийн хуваарийг дөрөвдүгээр, ерөнхий боловсролын сургуулийн төсвийн хуваарийг тавдугаар, сургуулийн өмнөх боловсролын төсвийн хуваарийг зургаадугаар, соёл, урлагийн байгууллагуудын төсвийн хуваарийг долоодугаар, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагуудын төсвийн хуваарийг наймдугаар, аймгийн төвийн шууд байгууллагуудын төсвийн хуваарийг есдүгээр, нийтийн биеийн тамирын байгууллагын төсвийн хуваарийг аравдугаар сангуудын төсвийн хуваарийг арван нэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан хуваарийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг олгож, хэрэгжилтийг хянаж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр үнэн зөв мэдээлж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010198